

Ариутгал халдваргүйтгэлийн тухай ерөнхий ойлголт

Сувилахуйн Алба
АХТасаг

2019 он

Сургалтын агуулга:

- ЭМС-н 2014 оны 187дугаар тушаалын хэрэгжүүлэх, биелүүлж ажиллахад сувилагч таны үүрэг
- Дадлага сургалтаар:
 - Гар угаах халдваргүйжүүлэх
 - Тарилгын ширээг халдваргүйжүүлэх
 - Цагаан материал бэлтгэх

- Зорилго: Мэдлэг сэргээх

Сургалтын өмнө ба дараахь
үеийн мэдлэг үнэлэх тест авах

ЭМС-н 2014 оны 187дугаар тушаалд багаж хэрэгслийг:

Өндөр эрсдэлтэй

Дунд эрсдэлтэй

Бага эрсдэлтэй гэж ангилдаг

Өндөр эрсдэлтэй

Судас дотуур, эрхтэн түүний хөндий, эд рүү нэвтрэн орох багаж хэрэгсэл /мэс заслын, умайн хөндийд хэрэглэх, шүдний г.м бүх хагалгааны/

Дунд эрсдэлтэй

Салст бүрхэвч, гэмтэлтэй арьс салсттай хүрэлцдэг, оношилгооны дуран г.м багаж хэрэгсэл /хагалгааны бус дурангийн шинжилгээний хэрэгслүүд, интубацийн гуурс, утлаганы аппаратны хошуу, чихний цэвэрлэгээний хэрэгсэл, чихний дурангийн хошуу, үтрээний толь, үтрээний дуран, амбу маск, лазерын хошуу, мэдээгүйжүүлгийн хэрэгсэл, хамрын гуурс г.м/

Бага эрсдэлтэй

Гэмтээгүй арьс салстай хүрэлцдэг, хүний бие, арьс салстад хүрдэггүй багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж / даралтын аппарат, пульс хэмжигч, чагнуур, усан эмчилгээний банн, зүрхний цахилгаан бичлэгийн хэрэгсэл, ЭХО-ны датчик, хүүхдийн жин г.м үйлчлүүлэгчийн орчны эд зүйлс энэ ангилалд/ гэж ангилсан байна.

Бохир багаж, хэрэгслийг ариутгалын тасагт хүргэх

А. Бохирлогдсон багаж хэрэгслийг тасаг нэгжид угааж, халдваргүйжүүлэхгүйгээр шууд зориулалтын битүү зөөврийн саванд хийж ариутгалын тасагт хүргэнэ.

Эмэгтэйчүүдийн үзлэг шинжилгээ, оношилгоо, эмчилгээнд хэрэглэсэн багаж хэрэгслийг тэр дор нь биологийн бохирдлыг арилгаж усаар угаах эсвэл уусмалд хийж ариутгалд хүргэнэ. Үтрээний шүүрэл, ялгадас нь багаж хэрэгсэлд хатвал толбо тогтох, арилгаж цэвэрлэхэд төвөгтэй байдаг. Мөн **хатсан цус** нь халдвар тараах эрсдэл өндөр тул хэрэглэсэн дарууд ариутгалын тасагт хүргэнэ.

Б. Бохирлогдсон багаж хэрэгслийг тоолж хүлээлгэж өгөх ба ариутгагч нь хүлээн авч бүртгэнэ.

В. Хэрэглэсэн багаж хэрэгслийн бикс, баглаа боодлын даавуу нь хуурай цэвэр, цус болон биологийн шингэнээр бохирлогдоогүй байна.

С. Тухайн тасаг хэрэглэгдэх байдлаараа өөр өөр савалгаа боодлоор багаж хэрэгслийг боолгуулах болон пакетлан ариутгуулж хэрэглэдэг. Удирдлагын зүгээс гарсан шийдвэрийн дагуу пакетлан бэлтгэх, боох зэрэг асуудал нь ариутгалын тасагт мэдээлсэн байдаг. Энэ шийдвэрийн дагуу боож бэлтгэх ажлыг ариутгагч нар гүйцэтгэнэ.

Ариун багаж материалыг хадгалах өрөө, хэсэг нь дараахь шаардлагыг хангасан байна

- Зөвшөөрөгдсөн хэсэгт хадгалах ба бусад газраас тусгаарлагдсан, Цэвэр хуурай, тоос, чийг, хорхой, шавьжнаас хамгаалагдсан байна.
- Өрөөний чийглэг 30-60%, температур нь 18-23градус байна.
- Хонгил, цонхны тавцан, шал, угаалтуур доор хадгалахгүй.
- Хадгалах тавиур тэргэнцэрийн гадаргуу нь цэвэрлэхэд тохиромжтой, гөлгөр, нүхгүй, цэвэрлэгээ болон халдваргүйтгэлийн бодисонд тэсвэртэй байна.
- Ариутгасан багаж материалыг чийг, тоосоор бохирдуулахгүй байна.
- Тавиур нь шалнаас дээш 25 см
- Хананаас 5 см
- Тааз болон галын хор, гал унтраагчаас 45 см
- Хадгалах, тээвэрлэхдээ ариун материалын савалгааны бүрэн бүтэн байдлыг хангах ёстой.

Зөөвөрлөх сав

- Ариун багаж хэрэгслийг зөөвөрлөх зориулалтын сав, тэргэнцэртэй байна.
- Тэргэнцэр нь хаалттай, тавиуртай, доод тавиур нь хатуу, хөдөлгөөний маневр сайтай тоормостой байх
- Ариун багаж материалыг зөөвөрлөхдөө гаднах уут, сав, баглаа боодлыг бохирдуулж болохгүй

Багаж материалын хэрэглээний менежмент

- Багаж материалын нөөцийг хэрэглэх менежменттэй байна. Тухайлбал: Эхэлж ирснийг нь хэрэглэх
- Ариун материалыг хэт ихээр нөөцөлж болохгүй
- Цэвэр ариун материалд хүрэхийн өмнө гараа заавал угаана.
- Шошгон дээрхи хугацааг харах
- Хэрэглэхийн өмнө сав, баглаа, боодлын бүрэн бүтэн байдлыг харна
- Нэг дор их хэмжээгээр ариутгах хэрэгслийг авч ариутгалд ачаалал үүсгэхгүй байх

Мэдлэг сэргээх:

Нянгийн спор болон бүх төрлийн бичил биетэнг устгах үйл явцыг **ариутгал** гэнэ.

Өндөр болон дунд эрсдэлтэй багажийг ариутгана.

Багаж хэрэгсэл дээр байгаа өвчин үүсгэгч бичил биетийг өвчин үүсгэхгүй хүртэл цөөрүүлэх, устгахыг **халдваргүйжүүлэх** гэнэ.

Түгээмэл хэрэглэгдэж байгаа ариутгалын аргууд:

- Өндөр даралттай уурын ариутгал
- Хуурай халууны ариутгал
- Бага хэмийн ариутгал / этилен оксид /

Гар угаах, халдваргүйжүүлэх заавар

Гарын ариун цэврийг дараахь 2 аргаар сахина.

1.Нүдэнд харагдахуйц хиртэй байх, биологийн шингэнээр гар бохирлогдсон, бээлийг өмсөхийн өмнө болон тайлсны дараа, хоол идэхийн өмнө, ариун цэврийн өрөөнд орсон тохиолдол бүрт **“саван, ус ашиглан гар угаах”**

2.Нүдэнд харагдахуйц хиргүй, биологийн шингэнээр бохирлогдоогүй үед **“спиртэнд суурилсан гар халдваргүйжүүлэх бодис ашиглан гар хурууг халдваргүйжүүлэх”**

Эрүүл мэндийн ажилтан нь ажил үүргээ гүйцэтгэхдээ дараахь 5 мөчид гарыг угааж эсвэл халдваргүйжүүлнэ.

1. Үйлчлүүлэгчид хүрэхийн өмнө
2. Үйлчлүүлэгчид хүрсний дараа
3. Шүлс, цус, цэр, шээс зэрэг биологийн шингэнд хүрэлцсэний дараа
4. Ажилбар хийхийн өмнө
5. Үйлчлүүлэгчийн орчны эд зүйлд хүрсний дараа

Гадаргуу халдваргүйтгэх цэвэрлэгээний бодис

Incidin® Plus

- Бүх төрлийн нян, вирусийг устгана (сүрьеэгийн үүсгэгч, MRSA зэрэг)
- Угааж болох бүх төрлийн гадаргууг халдваргүйтгэх өндөр хүчин чадалтай
- Патентжуулсан Гликопротамин® бодис агуулсан
- Халдваргүйтгэл, цэвэрлэгээний дараа өөрөө задарч устана.
- Халдваргүйтгэж буй гадаргууг гэмтээхгүй
- Байгаль орчинд хор нөлөөгүй
- Амин нэгдэлгүй
- Альдегидгүй

Хэрэглэх заавар:

- Incidin® plus-ыг хүйтэн усаар тохирох концетрацитай болтол шингэлж хэрэглэнэ.
- Талбай хатсан тохиолдолд гадаргууг халдваргүйтгэнэ
- Гадаргууг цэвэрлэхдээ нойтон алчуураар жигд норгон талбай үлдээлгүй арчина.
- Хэрэглэхийн өмнө бодисын хаяг тэмдэг болон найруулсан өдрийг унших ба халдваргүйтгэл хийхдээ гартаа бээлий өмсөнө
- Шүршиж хэрэглэж болохгүй

Ач холбогдол

Угааж болох бүх төрлийн гадаргууг халдваргүйжүүлэх өндөр хүчин чадалтай

Халдваргүйжүүлэх цэвэрлэгээний дараа өөрөө задарч устана.

Бүх төрлийн гадаргуу болон шалны цэвэрлэгээнд зориулалттай

Цагаан материал бэлтгэх

- Бэлтгэх ширээ болон гадаргууг бэлтгэнэ.
- Цэвэр даавуу болон хулдаас, пилонк дээр хийх ба хэрвээ шууд ширээн дээр хийх бол халдваргүйжүүлэх уусмалыг гадаргуунд хэрэглэ.
- Малгай маскийг хэрэглэсэн байна.
- Гараа угаах болон халдваргүйжүүлнэ.
- Материал дээрхи наалдсан гадны зүйлс бий эсэхийг сайтар шалгаж хийх
- Материал хийхдээ утасны өөдсийг илүү гаргахгүй нягт нямбай хийнэ.
- Хэрэглэх байдлаар тоолж баглах, тарилгын хөвөнг 3ш-р тус тусад нь боож бэлтгэнэ.
- Биксний дотор тал цэвэр байна.
- Ариутгалд өгөхдөө биксний дотор хугацаа хэтэрсэн үлдэгдэл материал байгаа эсэхийг шалгана.

Анхаарал хандуулсанд
Баярлалаа

Та бүхэнд ажлын
амжилт хүсье!